



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд дахь Гаалийн газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/125/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn
	Гэрээт аудитор:	Д.Дэмбэрэлсүрэн
		Цахим хаяг: demberelsurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.08.24 № 1-с/89

танай _____-ны № _____-т

САЙНШАНД СУМ ДАХЬ ГААЛИЙН
ГАЗРЫН ДАРГА О.ЦЭЭНРЭГЗЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгаагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	85.0	90.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,977.6	8,165.2
	Нийт хөрөнгийн дүн	6,062.6	8,255.8
	Нийт өр төлбөрийн дүн	2.0	0.4
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,060.7	8,255.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,062.6	8,255.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	4,281.7	3,694.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,122.1	1,499.9
	Үйл ажиллагааны үр дүн	3,159.6	2,194.8
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	0.02
	Үйл ажиллагааны нийт үр дүн	3,159.6	2,194.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,840.8	6,000.4
	Тайлант оны үр дүн	3,159.6	2,194.8
	Эцсийн үлдэгдэл	6,000.4	8,255.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,104.2	1,238.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	959.5	1,120.7
	Үйл ажиллагааны ЦМГ	144.7	117.5
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(144.7)	(117.5)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,232.5	1,238.2
	Урсгал зардал	1,232.5	1,238.2
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,232.5	1,238.2
	Улсын төсвөөс санхүүжих	1,232.0	1,231.9
	Татварын бус орлого	0.5	6.3

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

2021 оны Гаалийн ерөнхий газраас нийт системийн хэмжээнд “Хууль сахилт, ёс зүй сахилт, ёс зүй сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарласан.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Шатахууны тайлангийн анхан шатны баримтын бүрдэл болон нүүрсний 01 дүгээр сарын тайланд орлогодохдоо 3 дугаар сарын нэхэмжлэхээр хийгдсэн байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант онд Гаалийн шинэчлэлийн хүрээнд салбар лабораторийн хэвийн үйл ажиллагааг хангах 2.4 тэр бум төгрөгийн өртөг бүхий эрдэс түүхий эдийн шинжилгээ хийх лабораторийн тоног төхөөрөмжийг Гаалийн ерөнхий газраас хүлээж авсан байна. Бор өндөр салбарын ажилчдын амьдардаг байсан 55.8 сая төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг орон сууцыг ЗГ, ТӨБЗГ-ын тогтоолын дагуу шилжүүлэн авсан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,231.9 сая төгрөгийн 12 орлогын гүйлгээ, 199.2 сая төгрөгийн 16 зарлагын гүйлгээ, 199.2 сая төгрөгийн 16 худалдан авалтын гүйлгээ, өмч хөрөнгө, төсөв зарцуулах 95.6 сая төгрөгийн 6 тушаал, шийдвэрийг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад мэдээлэх шаардлагатай бүх мэдээллийг байршуулсан бөгөөд өмч, хөрөнгө зарцуулах 16.7 сая төгрөгийн 2 тушаал шийдвэрийг хугацаа хоцроосон байна.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шатахууны тайлан болон анхан шатны баримтын бүрдэл, шалгах санхүүгийн аудитаар өгсөн албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг анхаарч авч үзэх.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 23.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12.2 сая төгрөгийн алдааг залруулж, 1.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 10.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

1. Цалин тооцсон хүснэгтийг мөнгөн гүйлгээгээр шилжүүлсэн дүнтэй тулгахад 10 сарын цалинд Н.Дөлгөөн албан хаагчийн 1.3 сая төгрөгийн цалинг олгосон боловч нийгмийн даатгалын тайланд тайлагнахгүй орхигдуулсан, Бат-Очир албан хаагчийн ХАОАТ-ын зөрүүг 2 удаа давхардуулан Татварын хэлтсийн данс уруу шилжүүлсэн байна. Мөн 6 дугаар сарын ээлжийн амралт бодсон ажилчдын цалинг 7 дугаар сард тайлагнахдаа нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүүг 12.5%-иар тооцож цалинг дутуу олгосон байна. Үүнээс үүдэн татвараас 0.4 сая төгрөгийн авлага, нийгмийн даатгалд 0.3 сая төгрөгийн өглөг, хувь хүмүүст өгөх өглөг 0.1 сая төгрөгийн тус тус тооцоо үүслээ.
2. Номин тав трейд ХХК худалдааны төвөөс худалдан авсан 0.4 сая төгрөгийн бараа материалыг аж ахуйн бараа материалын дансанд бүртгэлгүйгээр шууд зардалд бүртгэсэн байна.
3. Нийт 9.6 сая төгрөгийн зардлыг буруу дансанд ангилан бүртгэж тайлагнасан байна.

Албан шаардлага

1. Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс худалдан авах зардлаас 0.3 сая төгрөгийн машины дугуйн төлбөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил гүйлгээний төлбөр хураамж зардлаас сургалтын төлбөр, тээврийн хэрэгслийн татвар, авто замын хураамж, 0.8 сая төгрөгийг нийт 1.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Зөвлөмж

1. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: 79.0 сая төгрөгийн гүйлгээний И-баримт байхгүй, 46.5 сая төгрөгийн нэхэмжлэх болон зарлагын баримт эх хувиараа байхгүй байна. Тайлант оны 01 дүгээр сард худалдан авсан нүүрсний орлогын баримтад 3 дугаар сарын нэхэмжлэхийг хавсарган нүүрсийг орлого авсан байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэлтийг хангах болон хүчин төгөлдөр баримтын үндсэн дээр гүйлгээг хийх.

2. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: 3 настай хонь 30000 төгрөг, хурга 10000 төгрөг, 2 болон 5 настай хонь 20000 төгрөгийн тус тус үнэлгээтэй байгаа нь зах зээлийн үнээс хэт доогуур үнэлгээтэй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Мал амьтдыг зах зээлийн бодит ханшаар бүртгэлд тусгах

3. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Шатахууныг талноор авахдаа зарлагын баримт авдаггүй, энэ нь тухайн үед шатахууны үнэ хэдэн төгрөг байсныг тогтоох боломжгүй, албаны машиныг унасан албан хаагчаар өөрсдөөр нь гарын үсэг зуруулдаггүй.

3.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийн хангах.

4. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Тайлант оны 01 дүгээр сарын түлш, шатах тослох материалын тайланд 10.0 сая төгрөгийн нүүрсийг орлого авахдаа 3 дугаар болон 4 дүгээр сарын нэхэмжлэхийн баримтыг хуулбараар хавсарган, бараа материалыг орлогодож, зарлагадсан байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын хүчин төгөлдөр байдлыг хангах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
НИЙТ									

8.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	8	23.4	3	12.2	-	-	1	1.2	4	10.0
НИЙТ		8	23.4	3	12.2	-	-	1	1.2	4	10.0